



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БОР-ӨНДӨР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 10 сарын 24 өдөр

Дугаар A/211

Бор-Өндөр сум

**Засаг даргын нөөцөөс хөрөнгө
зарцуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.20 дахь хэсэг, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр Тушаалын хавсралтаар баталсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.4, 2.1.5 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Бор-Өндөр сумын аварга шалгаруулах "Сагсан бөмбөг"-ийн тэмцээн 2024 оны 10 дугаар сарын 26,27-ны өдрүүдэд зохион байгуулагдах тул тэмцээний шүүгчийн зардалд 1,200,000 (нэг сая хоёр зуун мянга) төгрөг, Казакстан улсын Астана хотод болох Самбо бөхийн дэлхийн аварга шалгаруулах тэмцээнд монгол улсаа төлөөлж оролцож байгаа Р.Алтаннаран оролцож байгаа тул тэмцээний зардалд 1,200,000 (нэг сая хоёр зуун мянга) төгрөгийн дэмжлэг үзүүлж нийт 2,400,000 (хоёр сая дөрвөн зуун мянга) төгрөгийг зарцуулсугай.

2. Зардалд шаардагдах 2,400,000 (хоёр сая дөрвөн зуун мянга) төгрөгийг зохих хууль дүрэм, журмын дагуу Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг Засаг даргын тамгын газрын нягтлан бодогч (О.Мөнхцэцэг)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Г.АДЪЯАБИЛЭГТ